



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 31 өдөр

Дугаар А/536

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5 дахь заалт, Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Төрийн зарим чиг үүргийг бусдаар гүйцэтгүүлэх гэрээний дагуу аймгийн Хог хаягдлын менежментийг сайжруулах дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, нийтийн эзэмшлийн хогийг цэвэрлэх, ачиж зайлуулах, төвлөрсөн хогийн цэгийн отвольд зориулж 202,991,261 төгрөгийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулах 202,991,261 (хоёр зуун хоёр сая есөн зуун ерөн нэгэн мянга хоёр зуун жаран нэг) төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн 5.7-д туссан арга хэмжээнээс санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Эрдэнэбат) нарт зөвшөөрсүгэй.

3. Төлөвлөгөөний дагуу нийт ажил үйлчилгээг чанартай хийж гүйцэтгэн, тайлан мэдээг тухай бүрд ирүүлж, гэрээний хэрэгжилтийг 12 дугаар сарын 31-ний дотор тайлагнахыг “Шинэ Ховд Жаргалант ТҮК” ОНӨААТҮГ-ын дарга (Д.Алимаа)-д даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Х.Батболд)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ

Х.БАТБОЛД



8400001 1214

Zah A/536/Kh

Засаг даргын 2024 оны
07 дугаар сарын 31-ний өдрийн
А/536 дугаар захирамжийн хавсралт



“ШИНЭ ХОВД ЖАРГАЛАНТ ТҮК” ОНӨААТҮГ-ЫН ХУР ХОГ ХАЯГДАЛ, НИЙТИЙН
ЭЗЭМШЛИЙН ЗАМ ТАЛБАЙН ОРЧНЫ БОХИРДЛЫГ ЦЭВЭРЛЭХ, ТЭЭВЭРЛЭХ,
ОТВОЛЬ ХИЙХ ЗАДАРГАА

Д/д	Хэрэгжүүлэх ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж тарифын үнэ	Шаардлагатай төсөв /төгрөг/
1	Төвлөрсөн хогийн цэгийн 1,2 талбайг отвольдох, хогийн цэгийн зам дагуух хог цэвэрлэх, цугларсан хогийг өдөр бүр түрж, талбай гарган тэгшлэх	тн	22231	9131	202,991,261
НИЙТ ДҮН					202,991,261

-оОо-